



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 88

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах,
хөрөнгөд үнэлгээ тогтоож, худалдах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.6, 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванхоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сайхан-Овоо сумын Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 27,495,998.46 /хорин долоон сая дөрвөн зуун ерэн таван мянга есөн зуун ерэн найман төгрөг дөчин зургаан мөнгө/ төгрөгийн балансын үнэтэй 26,016,633.22 /хорин зургаан сая арван зургаан мянга зургаан зуун гучин гурван төгрөг хорин хоёр мөнгө/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 2 ширхэг барилгыг нэгдүгээр хавсралтаар, Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1,058,400 /нэг сая тавин найман мянга дөрвөн зуун/ төгрөгийн балансын үнэтэй, 882,000 /найман зуун наян хоёр мянган/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй модон гэрийг хоёрдугаар хавсралтаар акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Сайхан-Овоо сумын Цэцэрлэгийн эрхлэгч (Д.Сарнай), Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Б.Арсланбаатар) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Актлах барилгыг сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор буулгаж, акталснаас гарсан материалыг худалдан борлуулж, орлогыг орон нутгийн хөрөнгө худалдсаны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэх;

2.2 Үл хөдлөх хөрөнгийг буулгасны дараа чөлөөлсөн газрыг нөхөн сэргээж байгууллагын хэрэгцээнд зориулалтаар нь ашиглах;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4 Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА




С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
88 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

Сайхан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн актлах барилгын мэдээлэл

Д/Д	Хөрөнгийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглалтад орсон он	Ашиглалтын нийт хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			хэмжих нэгж	Биет хэмжээ					
1	Модон гэр	Музей	м2	74	1986	36	1,058,400	176,400	882,000
Дүн							1,058,400 /нэг сая тавин найман мянга дөрвөн зуун/ төгрөг		882,000 /найман зуун наян хоёр мянган/ төгрөг



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
88 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

Сайхан-Овоо сумын Хүүхдийн цэцэрлэгийн актлах барилгын мэдээлэл

Д/Д	Хөрөнгийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглалтад орсон он	Ашиглалтын нийт хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	
			хэмжээ их нэгж	Биет хэмжээ						
1	Шинэ цэцэрлэг	Өргөтгөл	м2	74	2005	60	26,832,231.23	1,346,611.64	25,485,619.59	
2	Модон склад	Склад	м2	16	1980	40	663,767.23	132,753.60	531,013.63	
Дүн										
							27,495,998.46		26,016,633.22	/хорин зургаан сая арван зургаан мянга зургаан зуун гучин гурван төгрөг хорин хоёр мөнгө/ төгрөг